БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ АСУУДАЛ



2017 он

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- 1998 онд шинээр батлагдсан
- 2001 онд нэмэлт өөрчлөлт орсон
- 2012 оны 05-р сарын 17-ны өдөр шинэчилсэн найруулга хийгдэж батлагдсан
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон дагалдах журмууд 2012 оноос мөрдөгдөж байна;

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

- 2012-2017 онуудад иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 3110 төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргасан байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

- 1995 оноос өнөөг хүртэл 5990 төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд шинжилгээ хийж, баталсан байна.

БОННҮ ЭРХ БҮХИЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг нийт 130 аж ахуйн нэгжид олгожээ.

Нарийн мэргэжлийн ажлын дадлага туршлага бүхий шинжээчидтэй, орчин үеийн мэдээллийн сантай, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй, санхүүгийн чадавхитай аж ахуйн нэгж цөөн байгаагаас үнэлгээний чанар хангалтгүй байна.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг уул уурхайн олборлолтын болон бусад томоохон төслүүдийн үнэлгээнд тусгаж байна;

Төслийн ангилал	Төрийн захиргааны төв байгууллага	Аймаг, нийслэлийн ЗДТГ
Уул уурхайн төсөл	Бүх төрлийн ашигт малтмалын олборлолт	Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд ашиг олох зорилгогүйгээр ашиглагдаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт
Хүнд үйлдвэрийн төсөл	Ашигт малтмалыг баяжуулах Боловсруулах Химийн үйлдвэр Кокс-химийн үйлдвэр Бусад бүх төрөл	
Хөнгөн, хүнсний үйлдвэрийн төсөл	Улсын чанартай томоохон үйлдвэр	Орон нутгийн жижиг дунд үйлдвэр
Хөдөө аж ахуйн төсөл	Усан сан Усжуулалтын систем Атар газар эзэмших үйл ажиллагаа	Орон нутагт хэрэгжих ойжуулалтын төсөл Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн Газар тариалангийн шилдвэр эрхлэх талбай
Дэд бүтцийн хөгжлийн төсөл	1 Мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц 35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам Дулааны шугам Усан цахилгаан станц Төмөр зам Нисэх буудал Улс, хот хоорондын зам Улс, хот хоорондын холбоо Нефтийн бүтээгдэхүүний агуулах	1 Мвт- хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц 35 кв хүртэл хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам Орон нутгийн чанартай зам, холбоо ШТС
Үйлчилгээний салбарын төсөл	50 ор хоногоос дээш хүчин чадалтай зочид буудал, амралт, сувилал, бусад үйлчилгээний газар	50 ор хоног хүртэл дээш хүчин чадалтай зочид буудал, амралт, сувилал, бусад үйлчилгээний газар
-Хот байгуулалт -Батлан хамгаалах болон иргэний хамгаалалтын зориулалтаар хэрэгжүүлэх төсөл -Усан хангамжийн систем -Цэвэрлэх байгууламж -Хог хаягдлын нэгдсэн цэг	10000-аас дээш хүн амтай төв, суурин газрын усан хангамж, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын нэгдсэн цэг Батлан хамгаалах болон иргэний хамгааллын зориулалтаар байгуулах улсын чанартай барилга байгууламж	10000-аас доош хүн амтай төв, суурин газрын усан хангамж, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын нэгдсэн цэг Батлан хамгаалах болон иргэний хамгааллын зориулалтаар байгуулах орон нутгийн чанартай барилга байгууламж
Биологийн төрөл зүйлийн төсөл	Улсын чанартай томоохон загасны аж ахуй Ан амьтан, ургамал нутагшуулах, ашиглах болон бусад үйл ажиллагаа	Ан агнуурын болон ойн аж ахуй, ангийн отог Тухайн дэвсгэр нутгийн хүн амын хэрэгцээг хангах зориулалттай загасны аж ахуй
Хувиргасан амьд организмтэй холбоотой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Хувиргасан амьд организмтэй холбоотой үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх Хувиргасан амьд организмыг гарган авах Үйлдвэрлэл эрхлэх Тариалах Импорттлох Хил дамжуулан худалдаалах	Хувиргасан амьд организмыг орон нутагт тариалах Түүнийг ашиглан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх Ойжуулах нөхөн сэргээлт хийх
Химийн хортой болон цацраг идэвхт бодис, аюултай хаягдлын төсөл	Химийн хортой болон цацраг идэвхит бодис, аюултай хаягдлыг боловсруулах, ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа	
Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсэд явуулах үйл ажиллагаа	Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газар нутагт явуулах үйл ажиллагаа

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог, ялангуяа тухайн төсөл хэрэгжих нутгийн иргэдийн оролцоог хангах зорилгоор олон нийтийн оролцооны талаар тусгай бүлгээр зохицуулсан.

БОДЛОГО

- Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах зорилгоор байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйгээр байгалийн нөөцийг ашиглах, үйлдвэр, үйлчилгээг эрхлэх, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг урьдчилан тогтооход оршино;

ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Байгаль орчны ерөнхий үнэлгээ:

Тулгарч буй бэрхшээл

- *Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргахад шаардлагатай бичиг бариммтад эрх бүхий байгууллагаар батлагдсан техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл шаардаж байгаа нь уул, уурхай ашиглах төслүүдээс бусад төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргахад хүндрэл учруулж байна.*

Шийдвэрлэх арга зам

- *Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журманд өөрчлөлт оруулах замаар уул уурхай ашиглах төслөөс бусад төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргахад зөвхөн шаардлагатай тохиолдолд техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг харгалзан үзэхээр зохицуулах.*

ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ:

Тулгарч буй бэрхшээл

- *Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үнэлгээний мэргэжлийн зөвлөл болон төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн багийн иргэдийн нийтийн хуралд танилцуулж, санал авч байгаа нь тухайн төслийг хэрэгжих орон нутгийн иргэдээс нь санал авч байгаа боловч зарим тохиолдолд БИНХ хуралдахгүй хугацаа алдсанаас төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжид хүндрэл учруулж байна.*

Шийдвэрлэх арга зам

- *Холбогдох журманд өөрчлөлт оруулах замаар зарим төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг шинжилгээ хийсэн шинжээчийн саналаар Ерөнхий шинжээч баталгаажуулах, зөвхөн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд багийн иргэдийн нийтийн хурлын саналыг авахаар зохицуулах.*

ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

БОННҮ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага:

Тулгарч буй бэрхшээл

- *Ихэнх мэргэжлийн байгууллагууд ажил эрхлэхэд шаардлагатай мэдээллийн сан, материаллаг бааз, боловсон хүчний чадавхи муутайгаас үнэлгээний тайлан нь өнөөгийн шаардлагыг хангахгүй байна.*

Шийдвэрлэх арга зам

- *Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд мониторинг хийх, үнэлгээний шинжээчдийг сургалтанд хамруулах замаар цөөн тооны чадварлаг аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох бодлогыг бариимтлана.*



www.mne.mn www.eic.mn

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА